

АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР, ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗАР, ПЕТРОЧАЙНА ДАЧИН ТАМСАГ ХХК ХООРОНД НИЙГМИЙН
ХАРУЦЛАГЫН ХҮРЭЭНД ХАРИЛЦАН ТОХИРОЛЦСОН
УУЛЗАЛТЫН ТЭМДЭГЛЭЛ

2018 оны 10 дугаар сарын 29-ны өдөр

Хэрлэн сум

1. Петровичайна Дачин Тамсаг ХХК нь Тамсаг ХХИ, Тосон-Уул ХИХ талбай тус бүрээс 200.000 /хоёр зуун мянга/ америк доллар буюу хоёр талбайгаас 400.000 /дөрвөн зуун мянга/ америк долларыг 2019 оноос эхлэн 5 жилийн хугацаанд жил бүр Дорнод аймгийн Орон нутгийн хөгжлийн санд шилжүүлнэ.
2. Аймгийн Засаг даргын Тамгын газраас орон нутгийн хөгжлийн санд төвлөрсөн мөнгөн дэмжлэгийн 30 хувийг газрын тосны олборлолтын үйл ажиллагаа явагдаж буй тухайн сумын орон нутгийн хөгжлийн санд шилжүүлнэ.
3. Петровичайна Дачин Тамсаг ХХК тус тэмдэглэлийн 1-т заасан мөнгөн дэмжлэгийг Аймгийн Засаг даргын Тамгын газраас хүргүүлсэн албан бичиг болон нэхэмжлэхэд үндэслэн тухайн оны 2 дугаар улиралд багтаан аймгийн орон нутгийн хөгжлийн санд шилжүүлнэ.
4. Газрын тосны олборлолтын талбай байршиж буй тухайн сум, орон нутгаас Петровичайна Дачин Тамсаг ХХК-д хандсан аливаа хандив, дэмжлэгийн шаардлагыг Дорнод аймгийн Засаг даргын Тамгын газар хариуцана.
5. Петровичайна Дачин Тамсаг ХХК-аас Дорнод аймгийн орон нутгийн хөгжлийн санд төвлөрүүлэх 400.000 /дөрвөн зуун мянга/ америк доллар нь өртөг нөхөх зардалд хамаарахгүй.

ТЭМДЭГЛЭЛИЙГ БАТАЛГААЖУУЛСАН:

АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ:	ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ:	ПЕТРОЧАЙНА ДАЧИН ТАМСАГ ХХК-ИЙГ ТӨЛӨӨЛЖ:
ГАЗРЫН ТОСНЫ АСУУДАЛ ХАРИУЦСАН ОРЛОГЧЦ.ЭРДЭНЭБАЯР	АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ	ЕРӨНХИЙЛӨГЧЖЯН ХУН ФУ